

# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2024 – 11 САР | ДУГААР 72

## ГАРЧИГ



- 2–3 Бодлогын нийтлэл
- 4 Зохицуулалтын мэдээ
- 5–6 Ярилцлага
- 7–8 Тогтвортой санхүүжилт
- 9–10 Компанийн засаглал, комплайнс
- 11–12 Финтек ба регтек
- 13–20 Судлаачийн индэр
- 21–22 Хамтын санхүүжилт гэж юу вэ?
- 23 Олон улсын зах зээлийн мэдээ
- 24 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

## ШИЛДЭГ 10: ФИНТЕК ДЕКАКОРН



Сэтгүүлийн энэ удаагийн дугаараар бид санхүүгийн салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж буй, зах зээлд 10 тэрбум ам.доллараас дээш үнэлгээтэй “Декакорн” хэмээх нэр хүндтэй статуст хүрсэн шилдэг 10 финтек компанийг онцлон танилцуулж байна. Тэдний хурдтай

өсөлт, шинэлэг шийдэл, зах зээлд үзүүлж буй томоохон нөлөөллийг энэ дугаараас та бүхэн сонирхон унших боломжтой.

Эдгээр компаниуд жил бүр хэдэн их наяд ам.долларын гүйлгээг боловсруулж, дэлхий даяар хэдэн зуун сая хэрэглэгчдэд санхүүгийн үйлчилгээг хүргэж байна. Энэхүү нийтлэл нь Fintech Magazine–аас эрхлэн гаргадаг “Шилдэг 10” цувралын хүрээнд бэлтгэгдсэн.

### 10. FNZ

- Гүйцэтгэх захирал: Blythe Masters
- Орлого: £1 тэрбум (ойролцоогоор 1.3 тэрбум ам.доллар)
- Төв байр: Лондон, Их Британи
- Ажилтнууд: 5,001–10,000
- Үүсгэн байгуулагдсан: 2003 он

FNZ нь хөрөнгийн удирдлагын технологийн салбарт тэргүүлэгч компани бөгөөд 2022 оны 2–р сарын байдлаар 20 тэрбум ам.долларын үнэлгээтэй болж, 10 тэрбум ам.доллараас дээш үнэлгээтэй “Декакорн” компаниудын эгнээнд багтжээ. FNZ нь дэлхийн хэмжээнд томоохон санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж, 24.0 сая хөрөнгө оруулагчийн өмнөөс 1.5 их наяд ам.доллараас дээш хөрөнгийг удирддаг. Тус компанийн хурдацтай өсөлт нь ухаалаг стратегийн үр дүн бөгөөд үүнд бусад компанийг худалдан авах, 650 гаруй санхүүгийн байгууллагатай түншлэх зэрэг алхмууд багтдаг.

Үргэлжлэлийг 10–р нүүрт



## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

### ШУДАРГА БАЙДАЛ

*Авлигад өртөхгүй байх, гуйвамтгай бус байдал, голч чанарыг илэрхийлдэг, үнэнч шударгатай ойролцоо утгатай үг. Төрийн албанд ажиллагчдын хувьд шударга байх зарчим нь аливаа гадны этгээд, байгууллагын өмнө албан үүргээ гүйцэтгэхэд нөлөөлж болох санхүүгийн болон бусад үүрэг амлалт авахгүй байхыг шаарддаг.*



### INTEGRITY

*It is defined as incorruptibility, an unimpaired condition or soundness, and is synonymous with honesty. In terms of public service, integrity requires that holders of public office should not place themselves under financial and other obligation to outside individuals or organizations that may influence them in the performance of their official duties.*

*Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал,  
нэр томъёоны тайлбар толь бичиг*

## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### НОГООН БОНДЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БҮЙ БОДЛОГО, ЧИГЛЭЛ

Уур амьсгалын өөрчлөлт нь дэлхий дахинд тулгарч буй хамгийн ноцтой асуудлуудын нэг бөгөөд үүний сөрөг нөлөө аль хэдийн ил тод мэдрэгдэж эхэлсэн. Монгол Улсад сүүлийн 80 жилд агаарын температур 2.4°C хэмээр өсөж, жилийн дундаж хур тунадас 7.3 хувиар буурсан бол хүлэмжийн хийн ялгаралт нэг хүнд ногдох хэмжээгээр дэлхийн дунджаас 2.7 дахин өндөр үзүүлэлттэй байна. Үүнээс гадна гамшигт үзэгдлийн давтамж сүүлийн 20 жилд хоёр дахин нэмэгдэж, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эдийн засгийн болон байгаль орчны эрсдэл ихэссээр байна.

Эдгээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ногоон эдийн засагт шилжих шаардлага улам тодорхой болж буй энэ цаг үед Монгол Улс “Алсын хараа–2050” урт хугацааны хөгжлийн бодлого болон Парисын хэлэлцээрийн хүрээнд 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгаралтыг 22.7 хувиар бууруулах амлалт өгсөн. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд тогтвортой санхүүжилт, ялангуяа ногоон бонд нь онцгой үүрэгтэй.

#### Ногоон бонд ба түүний ач холбогдол

Ногоон бонд нь байгаль орчны тогтвортой байдлыг хангах, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах, тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжих зэрэг ногоон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилго бүхий үнэт цаас юм.

#### Ногоон бондын зохицуулалт


Монгол Улсад ногоон бондын зах зээлийг хөгжүүлэх анхны алхам болгон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2019 онд “Ногоон таксономи”-ийг баталж, 2021 онд Санхүүгийн зохицуулах хорооноос “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталсан. Энэ журмаар дотоодын аж ахуйн нэгжүүд биржийн зах зээл дээр нээлттэй хүрээнд ногоон бонд гаргах замаар санхүүжилт татах боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн 2023 онд Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны “Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам”-ын шинэчилсэн найруулгыг батламжилснаар биржийн бус зах зээлд ногоон бонд гаргах тогтолцоо бүрдсэн чухал алхам болсон.

“Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д туссан нэгэн голлох зохицуулалт бол нийтэд санал болгох тодорхой үнийн дүн бүхий ногоон бондыг бүхэлд нь нэг удаа бүртгүүлж, тэдгээрийг нэг удаа, эсхүл хэд хэдэн удаа хэсэгчлэн санал болгож, санал болгох бондын тоо, татан төвлөрүүлэхээр зорьж байгаа хөрөнгийн хэмжээ, үндсэн болон хүүгийн төлбөр төлөх нөхцөл, үнэ, хүү нь харилцан адилгүйгээр санхүүжилт татах боломж юм. Энэ нь санхүүжилтийн хэрэгцээ, шаардлага, хөрөнгө оруулагчдын сонирхол зэргээс шалтгаалан бонд гаргах тохиромжтой үеийг ашиглан санхүүжилт татах боломжийг бий болгож байгаа юм.

Ногоон бонд гаргагч нь хөтөлбөрийн хүрээнд бонд гаргах бол хөтөлбөр хэрэгжүүлэх тухайгаа бондын танилцуулгадаа тусгах шаардлагатай бөгөөд 6 сар тутам бондын танилцуулгыг шинэчлэн Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэн нийтэд мэдээлэх зохицуулалттай.

Мөн эхний хөтөлбөрийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлснээс хойш 6 сарын дотор хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд дараа дараагийн хөтөлбөр нь хөрөнгө оруулалтын төрлөөс хамааран 12–24 сарын дотор хэрэгжинэ.

### Ногоон бонд гаргах үе шат



### Ногоон бондын гаргалтыг өргөжүүлэх чиглэлээр төлөвлөсөн ажлууд

Дэлхийн олон улс оронд ногоон бондын зах зээл хурдацтай хөгжиж, санхүүгийн шинэ эх үүсвэр бий болгож байна. Монгол Улсад ногоон бонд гаргах нь зөвхөн байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжихээс гадна хөрөнгийн зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, олон улсын зах зээлтэй холбогдох шинэ боломжийг нээх юм. Иймд Монгол Улсын хөрөнгийн зах зээлд ногоон бонд гаргалтыг дэмжих зорилгоор дараах ажлуудыг хэрэгжүүлэхийг зорьж байна. Үүнд:

- **Ногоон бондын баталгаажуулалт (Green bond verification):** Санхүүжилтийн хөрөнгө зөвхөн ногоон төслүүдэд зарцуулагдаж буй эсэхийг баталгаажуулах хөндлөнгийн хяналтын механизмыг бий болгох.
- **Ногоон бондын батлан даалт (Green bond guarantee):** Хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхийн тулд батлан даалтын тогтолцоог бий болгох.

Монгол Улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авч буй арга хэмжээний голлох хөшүүрэг нь тогтвортой санхүүжилт, тэр дундаа ногоон бонд юм. Энэ нь зөвхөн санхүүжилтийн шинэ эх үүсвэрийг бүрдүүлээд зогсохгүй, байгаль орчныг хамгаалах, олон улсын ногоон хөрөнгө оруулалтыг татах үндэс суурь болно. Энэ хүрээнд цаашид ногоон бондын бодлогын орчныг улам боловсронгуй болгох нь Монгол Улсын эдийн засаг, байгаль орчин, хөрөнгө оруулагчдын эрх ашгийн төлөөх чухал алхам юм.

## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### КОМПАЙНСЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААР ХЭЛЭЛЦЛЭЭ



Компанийн засаглалын тогтолцоо, компайнсыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь аливаа компанийн урт хугацааны тогтвортой хөгжил цаашлаад санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангагч суурь нөхцөл юм. Иймд Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн салбарын компайнсын зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, компайнсын эрсдэлийг үр дүнтэй удирдах, байгууллагын соёлыг бий болгох, түүнийг хэвшүүлэх зорилтын хүрээнд нэлээдгүй ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд үүний нэг болох “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, компайнсын эрсдэлийн удирдлага нээлттэй хэлэлцүүлгийг энэ сарын 06-нд зохион байгууллаа.

Даатгагч, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн компани, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн 80 гаруй төлөөлөл оролцсон энэ удаагийн хэлэлцүүлгээр “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, компайнсын эрсдэлийн үнэлгээ, өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, шийдэл ба боломжүүд, цаашдын чиг хандлагын талаар хэлэлцэв.

Хэлэлцүүлэгт оролцогчид компанийн засаглалын зохицуулалтын орчин, ялангуяа кодекс болон эрсдэлийн үнэлгээний аргачлалыг манай орны туршлага, бусад орны сайн жишигт нийцүүлэн тогтмол боловсронгуй болгох зорилгоор тулгарч буй асуудал, бэрхшээлийг шийдвэрлэхэд үр дүнтэй мөн гарц, шийдэл бүхий хэлэлцүүлгийг цаашид тогтмол зохион байгуулах хүсэлтээ энэ үеэр илэрхийлсэн юм.

### АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГАА ЭХЛҮҮЛЛЭЭ

“Шунхлай” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй Шунхлай бондын анхдагч зах зээлийн арилжааны цан цохих ёслол боллоо. Ёслолд Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, Монголын хөрөнгийн биржийн бизнес хөгжлийн газрын захирал Т.Хаш-Эрдэнэ, “Шунхлай” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ж.Мөнхнаран, “Голомт капитал ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал

С.Ган-Эрдэнэ болон холбогдох бусад хүмүүс оролцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Санхүүгийн зохицуулах хороо олон тулгуурт санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, тэр дотроо хөрөнгийн болон даатгалын зах зээлийн тогтвортой хөгжлийг бий болгоход зохицуулалтын бодлого, арга хэмжээгээ чиглүүлж ажиллаж ирлээ. Энэ оны гуравдугаар улирлын байдлаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 12.4 их наяд төгрөг буюу 2020 онтой харьцуулахад 4.8 дахин өсч, хөрөнгийн биржийн арилжааны хэмжээ 1 их наяд төгрөг даваад байна. Мөн ДНБ-д эзлэх хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 17.7 хувь болж өссөн, сүүлийн 4 жилийн хугацаанд бодит секторт үйл ажиллагаа явуулж буй манай компаниуд хөрөнгийн зах зээлээс нийтдээ 5.3 их наяд төгрөгийн санхүүжилт татаж үйл ажиллагаагаа санхүүжүүлсэн зэргээс харахад энэ зах зээлийн улс орны эдийн засагт гүйцэтгэх үүрэг жил ирэх тусам өсөж байгаа нь тодорхой харагдана. Ер нь хөрөнгийн зах зээл өндөр хөгжсөн улс орнуудын туршлагаас харахад бондын зах зээлээ эхэлж хөгжүүлсэн сайн туршлага байдаг. Санхүүгийн зохицуулах хороо ч мөн энэ чиглэлд анхаарч 2021 онд “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам” буюу бондын журмаа шинэчлэн баталж улмаар хөрөнгийн биржийн I ангилалд хувьцаа нь бүртгэлтэй хувьцаат компаниуд, Монгол Улсын ТОП-100 аж ахуй нэгжүүдээс гаргах бондыг ажлын 10 хоногт бүртгэх мөн санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон бол барьцаагүй бонд гаргах, бондын хөтөлбөр хэрэгжүүлэх, ногоон бонд гаргах зохицуулалтыг хэрэгжүүлж эхэлсэн. Мөн өнгөрсөн онд МҮХАҮТ-тай хамтран компаниудын хөрөнгийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээний талаарх хөтөлбөрийг баталсан. Энэ хүрээнд аж ахуйн нэгжүүдийг IPO хийх, компанийн бонд гаргахад тавигдах нөхцөл шаардлагыг багасгаж, үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулах замаар оролцоог нь өсгөж, холбогдох дүрэм, журамд зохих өөрчлөлт оруулан бодлогын арга хэмжээ авах чиг үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг байгуулан ажиллаж байна. Ингэхдээ аж ахуй нэгжүүдийг хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татахыг дэмжин ажиллаж мөн холбогдох хууль, журмыг шинэчлэн сайжруулж байгаа бөгөөд үр дүн ч тодорхой хэмжээгээр гарч байна. ТОП-100 компаниудаас ч хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах сонирхол нэмэгдэж түүнийг дагаад зах зээлд чанартай, шинэ бүтээгдэхүүнүүд ихээр гарч, хөрөнгө оруулагчдад ч сонголт өргөн болж байна” гэсэн юм.



## ЯРИЛЦЛАГА

### ББСБ–УУДЫН ОЛГОХ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛД ӨР, ОРЛОГЫН ХАРЬЦАА ТОГТООЛОО

Санхүүгийн зохицуулах хорооноос ББСБ–ын салбарт авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний талаар Банк бус санхүүгийн байгууллагын газрын бодлогын чиглэлийн ахлах референт Н.Баярсайхантай ярилцлаа.

**ББСБ–уудын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр салбарт мөрдөгдөж буй журмуудыг шинэчилсэн гэсэн. Энэ талаар мэдээлэл өгнө үү?**

**Н.Баярсайхан:** Санхүүгийн зохицуулах хороо нь хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд холбогдох журам, зааврыг батлан, мөрдүүлэн ажиллаж байна. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо дангаараа болон бусад холбогдох төрийн байгууллагатай хамтран баталсан нийт 18 журам, заавар, аргачлал мөрдөгдөж байна. Сүүлийн жилүүдэд салбарын оролцогчдын хувьд олон талт болон технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг иргэдэд хүргэх, зөвхөн өөрийн хөрөнгөөр бус бусад зохицуулалтаар зөвшөөрөгдсөн санхүүгийн эх үүсвэрийг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн 2024 оны III улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй 555 ББСБ–уудын 88.6 хувь нь зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд салбарын нийт зээлийн багц 5.4 их наяд төгрөгт хүрч, зээлийн үлдэгдлийн 58.7 хувийг иргэний хэрэглээний зээл, үүний 27 хувийг автомашинд зориулсан зээлийн үлдэгдэл эзэлж байна. Эндээс харахад салбарын хэрэглээний зээл болон суудлын автомашин барьцаалсан зээл өндөр байгаа нь харилцагчийг өрийн дарамтад оруулах, гадагшаа урсах валютын урсгалд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Иймээс Санхүүгийн зохицуулах хорооноос салбарт үүсч болзошгүй эрсдэлийг бууруулах, эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой болгох, салбарын оролцогчдыг чадавхжуулах, нийгэмд үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор бодлогын томоохон зохицуулалтыг 2024 оны 11 дүгээр сарын Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит хуралдаанаар шийдвэрлэлээ. Үүнд: Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмыг шинэчлэн баталлаа. Энэхүү журмаар хуульд заасан 9 төрлийн үйл ажиллагаанд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг тодорхойлж, хувь нийлүүлсэн

хөрөнгийн доод хэмжээг Улаанбаатар хотод 5,000,000,000 төгрөг, Дархан–Уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Баян–Өндөр сум, Төв аймгийн Зуунмод сумдад 1,200,000,000 төгрөг, бусад аймаг сумдад 400,000,000 сая төгрөг байхаар заасан бол итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тохиолдолд орон нутаг харгалзахгүйгээр 10,000,000,000 төгрөг байхаар журамласан. Мөн эх үүсвэр татан төвлөрүүлж буй ББСБ–уудын өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг нь сайжруулж, хүн амын амжиргааны түвшнээс бага дүнтэй активын үлдэгдлийг тодорхой нөхцөлийг хангасан тохиолдолд шатлал үл харгалзан хэвийн ангилал хүртэл дээшлүүлж болохоор зохицуулсан. Харин тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ–уудын хувьд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх хуваарийг баталсан. Тухайлбал, 2,5000,000,000 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ–уудын хувьд 2026 онд 3,500,000,000 төгрөгт 2028 онд 5,000,000,000 төгрөгт хүргэх бол итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ–уудын хувьд 2026 онд 5,000,000,000 төгрөг, 2028 онд 10,000,000,000 төгрөгт хүргэх зэргээр орон нутгийн ББСБ–уудын хувьд ч мөн ижил үе шаттайгаар 2028 онд гэхэд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангахаар шийдвэрлэсэн. Мөн ББСБ–уудаас олгох бүх хэрэглээний зээлд өр, орлогын харьцааг 70 хувиар, суудлын автомашин барьцаалсан хэрэглээний зээл, үнэлгээний харьцаа 70 хувиас хэтрэхгүй байхаар шийдвэрлэсэн.

**Өр, орлогын харьцааг СЗХ–оос тогтоох хууль эрх зүйн үндэслэл байгаа юу?**

**Н.Баярсайхан:** Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулиар эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн үйл ажиллагаатай холбогдсон журмыг Санхүүгийн зохицуулах хороо баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина гэж заасан байдаг. Энэ эрхийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 160 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”–ыг баталсан. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 556 дугаар тогтоолоор дээр дурьдсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулж ББСБ–ын зээлийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагад хэрэглээний зээлийн

бүтээгдэхүүнд тооцох өр, орлогын харьцаа болон суудлын автомашин барьцаалсан хэрэглээний зээл, үнэлгээний харьцааг тус тус хангаж ажиллахаар заасан. Өр, орлогын харьцааг тооцоходоо Монголбанкнаас баталсан “Өр, орлогын харьцаа тооцох аргачлал”-ыг мөрдөх ба энэхүү харьцаа нь Монгол Улсын ногоон таксаномийн ангилалд хамаарах ногоон зээлд хамаарахгүй байхаар зохицуулсан.

**Суудлын автомашины зээлд зээл, үнэлгээний харьцаа тогтоосон гэсэн. Энэ нь юу гэсэн үг вэ?**

**Н.Баярсайхан:** 2024 оны III улирлын байдлаар ББСБ-уудаас олгосон зээлийн 93.1 хувь буюу 7.9 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд буюу хэрэглээний зээлд олгосон байна. Мөн оны байдлаар зээлийн үлдэгдлийн хэрэглээний зээлийн 27 хувийг автомашинд олгосон зээлийн үлдэгдэл эзэлж байна. Эндээс харахад Монгол Улсад худалдаалагдаж байгаа хуучин автомашины борлуулалт нь ББСБ-уудаар санхүүжигдэн иргэдэд хүрч байна. Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон дээрх шийдвэрийн хүрээнд ББСБ нь харилцагч 30 сая төгрөгийн үнэлгээтэй автомашин худалдан авахаар зээлийн хүсэлт ирүүлсэн бол тухайн харилцагч урьдчилгаа 9.0 сая төгрөгийг төлсөн тохиолдолд ББСБ нь үлдсэн 21.0 сая төгрөгт нь зээл олгоно. Өөрөөр хэлбэл харилцагч авах гэж байгаа автомашиныхаа урьдчилгаа 30 хувийг заавал төлнө гэсэн үг юм.

**Өр, орлогын харьцааг хэрхэн тооцно гэсэн үг вэ? жишээ нь сая төгрөгийн цалинтай хүн хэр хэмжээний зээл авах боломжтой вэ?**

**Н.Баярсайхан:** Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны 527 дугаар тогтоолоор ББСБ-уудаас олгох финтек зээлийн бүтээгдэхүүнд өр, орлогын харьцааг 70 хувиас хэтрэхгүй байхаар шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэрийг зөвхөн аппликэйшнээр зээл олгож буй ББСБ-ууд мөрдөж ажиллаж байгаа бөгөөд иргэдийн олон аппликэйшн ашиглан олон зээл зэрэг авах боломжийг хааж улмаар өрийн дарамтад орох эрсдэлийг бууруулсан. Гэсэн хэдий ч дээр дурьдсанчлан салбарын хэрэглээний зээлийн өсөлт нь өндөр байгаа нь иргэдийг өрийн дарамтад оруулах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Монголбанкнаас өр, орлогын харьцааг тогтоосонтой холбоотойгоор банк нь харилцагчийн хэрэглээний зээлд энэхүү харьцааг мөрдөн ажиллаж байгаа тул иргэд хэрэглээний зээлийг ББСБ-уудаас авах байдлаар хэрэгцээгээ хангаж байна. Иймээс Санхүүгийн зохицуулах хорооноос иргэдийг өрийн дарамтаас урьдчилан сэргийлэх, иргэдийн ажил эрхлэлтийг дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэх,

жижиг дунд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор өр, орлогын харьцааг тогтоосон. Жишээлбэл, 1,000,000 төгрөгийн цалинтай иргэний хувьд нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар төлсний дараах үлдэх орлогын 70 хувьд зээл олгогдоно. Өөрөөр хэлбэл, тухайн иргэн зээлгүй тохиолдолд 549.0 мянган төгрөгийн зээл авах боломжтой юм.

**Дээрх шийдвэрийг ББСБ-ууд шууд мөрдөөд явах уу? Зээлтэй байгаа иргэдэд энэ хамаарах уу?**

Захиргааны ерөнхий хууль 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш төрийн байгууллагаас гаргасан захиргааны хэм хэмжээний акт нь захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр мөрдөгдөхөөр хуульчлагдсан. Иймд Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанаар баталсан журмуудыг захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр Хууль зүй дотоод, хэргийн яамд хүргүүлсэн байгаа. Иймээс Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгэгдсэн өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэнэ. Мөн өр, орлогын харьцаа болон зээл, үнэлгээний харьцаа нь одоо зээлтэй иргэдэд хамаарахгүй бөгөөд дээр дурьдсанчлан журам бүртгэгдсэн өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэнэ.

**Бодлогын арга хэмжээнүүдийн ач холбогдол юу вэ?**

**Н.Баярсайхан:** Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлсэн дээрх бодлогын арга хэмжээнүүдийн хүрээнд: Нэгдүгээрт: үйл ажиллагааны зохицуулалт тодорхой болж, хуулийн төслийн суурь нөхцөл бүрдэнэ. Хоёрдугаарт, банк бус санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлснээр үйл ажиллагааны эрсдэл буурч, санхүүгийн чадавхи, өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж улмаар зээлийн хүүгийн хэмжээ буурна гэсэн тооцоолол байна. Гуравдугаарт, хэрэглээний зээлд өр, орлогын харьцаа мөрдөгдсөнөөр иргэдийн өрийн дарамтыг 35 хувиар бууруулах буюу тэр хэмжээгээр хэрэглээний зээл хумигдаж, бизнесийн зээлийн хэмжээ нэмэгдэх байх гэсэн урьдчилсан төсөөлөл байна. Мөн ББСБ-аас олгох суудлын автомашины хэрэглээний зээл, үнэлгээний харьцаа тогтоосноор импортын автомашины санхүүжилт буурч, тодорхой хэмжээгээр валютын гадагшлах урсгалыг бууруулж, улмаар автомашины түгжрэлийг бууруулахад энэхүү бодлогын арга хэмжээ тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулна гэж үзэж байна. Нөгөө талаас ББСБ-уудын макро эдийн засагт үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ харж байна.

# ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

## НИЙГМИЙН БОНДЫН ЗАРЧИМ

**Нийгмийн бонд** гэдэг нь татан төвлөрүүлсэн хөрөнгө түүнтэй тэнцэх хэмжээний мөнгийг шинэ болон хэрэгжиж буй зохих Нийгмийн төслүүдийг хэсэгчлэн бүхлээр нь санхүүжүүлэх эсвэл дахин санхүүжүүлэхэд зарцуулах бүх төрлийн бондын хэрэгсэл юм.

### Нийгмийн бондын төрлүүд:

- **Анхны нийтийн арилжааны орлогын бондын нийгмийн стандарт ашиглалт:** Зөвхөн үнэт цаас гаргагчид солих нөхцөлтэй, нийгмийн бондын зарчим (SBP)–д нийцсэн барьцаагүй өрийн үүрэг;
- **Нийгмийн орлогын бонд:** Бондын зээлийн өртөмтгий байдал нь орлогын урсгал, хураамж, татвар гэх мэт барьцаалагдсан мөнгөн хөрөнгийн урсгалд хамаарах, мөн түүний анхны нийтийн арилжааны орлого хамааралтай болон хамааралгүй Нийгмийн төсөл(үүд)–д зарцуулагддаг, SBP–тай нийцсэн үнэт цаас гаргагчид солих нөхцөлгүй өрийн үүрэг;
- **Нийгмийн төслийн бонд:** Хөрөнгө оруулагч нь төсөл(үүд)–ийн эрсдэлд шууд өртөх эрсдэлтэй ба үнэт цаас гаргагчид солих нөхцөлтэй эсвэл нөхцөлгүй, SBP–тай нийцсэн нэг буюу хэд хэдэн Нийгмийн төсөл(үүд)–ийн бонд;
- **Нийгмийн барьцаат бонд:** Цэвэр анхны нийтийн арилжааны орлогыг зөвхөн дараах зүйлсийн аль нэгийг санхүүжүүлэх эсвэл дахин санхүүжүүлэхэд ашиглах барьцаатай бонд.

### Нийгмийн бондын зарчмууд (SBP):

SBP нь Нийгмийн бонд гаргах арга барилыг тодорхой болгох замаар ил тод, нээлттэй байх болон Нийгмийн бондын зах зээлийг хөгжүүлэхийг уриалдаг процессын сайн дурын удирдамж юм. SBP нь үнэт цаас гаргагчдад найдвартай нийгмийн бонд гаргахад шаардлагатай гол бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар зааварчилгаа өгөх, нийгмийн бондын хөрөнгө оруулалтын эерэг нөлөөллийг үнэлэхэд шаардлагатай мэдээллийн хүртээмжийг дэмжих замаар хөрөнгө оруулагчдад дэмжлэг үзүүлэх мөн гүйлгээг хөнгөвчлөх, зах зээлийн

нэгдмэл байдлыг хадгалах зэрэг нэн чухал үүргүүдтэй юм. SBP нь хөрөнгө оруулагчид, банкнууд, андеррайтерууд, зээлийн зуучлагчид, хөрөнгө оруулалтын агентлагууд болон бусад хүмүүс аливаа нийгмийн бондын шинж чанарыг ойлгохын тулд ашиглаж болох тодорхой үйл явц, тайлагналыг үнэт цаас гаргагчдад санал болгодог.

Нийгмийн бондын зарчим дараах дөрвөн гол бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:



### 1. ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Нийгмийн бонд нь үнэт цаасны эрх зүйн баримт бичигт тусгасан нийгмийн төслүүдэд бондын хөрөнгийг зарцуулах бөгөөд эдгээр төслүүд нь нийгэмд тодорхой үр өгөөжтэй байх шаардлагатай. Үнэт цаас гаргагч нь нийгмийн төслүүдийг үнэлж, боломжтой бол тоон үзүүлэлтээр тодорхойлно. Хөрөнгийг ашиглахдаа хөрөнгө оруулалтын болон санхүүжүүлэх төслүүдийн хугацаа болон санхүүжилтийн эзлэх хувийн жинг харьцуулсан тооцоо гаргах шаардлагатай.

Нийгмийн төслүүдийн зорилго нь нийгмийн тодорхой асуудлыг шийдвэрлэх, нийгэмд эерэг үр дүн авчрах, хүн амын сайн сайхан байдалд заналхийлж, саад учруулж байгаа хор хөнөөлийг багасгахад чиглэдэг. Нийгмийн төслүүдэд хөрөнгө, хөрөнгө оруулалт болон дэмжих зардал, тухайлбал, нэгээс олон ангилалд хамаарах судалгаа, хөгжүүлэлт зэрэг багтдаг.



Ундны ус, бохирын шугам зэрэг боломжийн үнэтэй суурь дэд бүтэц	Эрүүл мэнд, боловсрол зэрэг зайлшгүй шаардлагатай үйлчилгээний хүртээмж	Боломжийн үнэтэй байр сууц	Нийгэм, эдийн засгийн хямрал, уур амьсгалын өөрчлөлтийн төсөл, хөтөлбөрүүд	Хүнсний аюулгүй байдал, хүнсний тогтвортой тогтолцоо	Нийгэм-эдийн засгийн дэвшил, эрх мэдлийг нэмэгдүүлэх, түүний дотор орлогын тэгш бус байдлыг бууруулах.
--	---	----------------------------	--	--	--



## 2. ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ БА СОНГОЛТ ХИЙХ ҮЙЛ ЯВЦ

Нийгмийн бонд гаргагч нь хөрөнгө оруулагчдад дараах зүйлийг мэдээлэх ёстой:

Нийгмийн төслүүдийн нийгэмд чиглэсэн зорилтууд;

Тухайн төслийг нийгмийн төслийн ангилалд хэрхэн тохирч байгааг тодорхойлсон, зорилтот хүн амд үзүүлэх үр өгөөжийг харуулсан шинжилгээ;

Холбогдох төслүүдийн нийгмийн болон байгаль орчны эрсдэлүүдийг тодорхойлж, түүнийг арилгах үйл явцын талаарх нэмэлт мэдээлэл.

Мөн нэмэлтээр:

Үнэт цаас гаргагчийн ерөнхий зорилго, стратеги болон нийгмийн тогтвортой байдалтай холбоотой мэдээллүүдийг байршуулах;

Холбогдох шалгууруудын талаарх мэдээллээр хангах, төслийг сонгон шалгаруулахад ашигласан нийгмийн стандарт, гэрчилгээг ил тод болгох;

Холбогдох төслийн нийгэм болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, материаллаг эрсдэлийг бууруулах хүчин зүйлсийг тодорхойлох;

Эрсдэлийг болзошгүй гэж үнэлсэн тохиолдолд эрсдэлийг бууруулах хүчин зүйлс нь тодорхой, харьцуулсан дүн шинжилгээ хийх шаардлагатай.



## 3. ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА

Нийгмийн бондын хөрөнгийг үнэт цаас гаргагч тусгай дэд дансанд байршуулах бөгөөд нийгмийн төслүүдэд зориулсан зээл олгох, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой албан ёсны зарцуулалтыг дотоод журмаар баталгаажуулсан байдаг. Нийгмийн бондын цэвэр хөрөнгийн үлдэгдлийг

тухайн хугацаанд хийгдсэн нийгмийн төслүүдэд олгосон хуваарилалттай тогтмол хугацаанд тохируулж тооцох, хуваарилагдаагүй цэвэр хөрөнгийн үлдэгдлийг түр байршуулах бол хөрөнгө оруулагчдад мэдэгдэх ёстой. Нийгмийн бондын хөрөнгийг бонд тус бүрээр эсвэл багцаар удирдаж болно.

SBP нь ил тод байдлын илүү нарийвчилсан шаардлагыг хэрэгжүүлэхээр дотоод хяналтын тогтолцооноос гадна бондын хөрөнгө хуваарилалтыг хөндлөнгийн аудитор эсвэл гуравдагч этгээдийг оролцуулах замаар баталгаажуулахыг зөвлөдөг.



## 4. ТАЙЛАГНАЛ

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө ашиглалтын талаарх тайланг жил бүр шинэчилж, өөрчлөлт оруулсан тохиолдолд тухай бүр оруулах шаардлагатай. Жилийн тайланд хөрөнгө хуваарилсан төслүүдийн жагсаалт, тухайн төслүүдийн товч тодорхойлолт, хуваарилсан хөрөнгийн хэмжээ, тухайн төслүүдийн хүлээгдэж буй үр нөлөөг тусгасан байна.

Хэрвээ үнэт цаас гаргагч нь нууцлалын тухай гэрээ, өрсөлдөөнтэй холбоотой болон бусад асуудлаар нарийвчилсан мэдээлэл өгөх боломжгүй тохиолдолд тайланд багцлан оруулж болно.

Төслүүдийн хүлээгдэж байгаа үр дүнг ил тод мэдээлэх нь хамгийн чухал бөгөөд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт болон тухайн төслийн үр дүнг тоон үзүүлэлтээр гаргах боломжтой тохиолдолд ашигласан арга зүй, таамаглалыг тайланд оруулах шаардлагатай.

Мөн үнэт цаас гаргагч нийгмийн бондын нөлөөллийн тайлагналыг тогтоосон заавар болон ICMA-ийн вэб сайтын тогтвортой санхүүжилтийн хэсэгт байгаа тайлагналын маягтуудаас ашиглах, дээрх дөрвөн гол бүрэлдэхүүн хэсгийг агуулсан нийгмийн бондын үр дүнгийн гол үзүүлэлтийг хураангуй тайланд тусгаж зах зээлийн оролцогчдод мэдээлэх, цахимд байршуулах боломжтой.

Эх сурвалж: ICMA (2023); MASD (2023). *The Social Bond Principles*

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

## КОМПЛАЙНСЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо (цаашид СЗХ гэх) зохицуулалтад хамрагдаж буй санхүүгийн салбарын комплайнсын зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, үйл ажиллагаа эрхлэхэд комплайнсын эрсдэлийг үр дүнтэй удирдах, байгууллагын соёлыг бий болгох, түүнийг хэвшүүлэх зорилтын хүрээнд СЗХ-ны даргын 2024 оны 52 дугаар тушаалын хавсралтаар “Комплайнсын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”-ыг баталсан.

Даатгагч, хөрөнгө оруулалтын менежментийн компани (ХОМК), итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн


байгууллага (ББСБ), виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (ВХҮҮ) компаниудад 2024 оны 5 дугаар сард дээр дурдсан аргачлалыг хэрхэн ашиглах талаар таниулах сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд зохицуулалттай этгээд нь комплайнсын эрсдэлээ өөрөө үнэлэх гарын авлагатай болсноор эрсдэлийн удирдлагыг бодитойгоор хэрэгжүүлэх суурь бүрдсэн юм.




“Комплайнсын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал” нь комплайнсын эрсдэлийг тодорхойлох ерөнхий 4 төрөл бүхий дараах 10 бүлэг эрсдэлийн хувилбараас бүрдэж байна.

Эрсдэлийн ерөнхий төрөл	Эрсдэлийн хувилбар
Ёс зүйн эрсдэл	Бизнесийн ёс зүй, нийгмийн хариуцлага
	Аудит ба залилан
Нэр хүндийн эрсдэл	Хээл, хахууль ба авлига
	Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа
Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл	МУТС, хориг арга хэмжээ, бодлого, дүрэм
	МУТС ба хориг арга хэмжээний хөтөлбөр
	Хориг арга хэмжээ
Үйл ажиллагааны эрсдэл	Хяналт, тайлагнал
	Төлбөрийн ил тод байдал
	Сургалт ба мэдлэг боловсрол

Зохицуулалттай салбаруудын комплайнсын эрсдэлийн судалгааг хийх зорилгоор даатгагч, ХОМК, ББСБ болон ВХҮҮ-дийн дээрх аргачлалын дагуу өөрийн компанийн

комплайнсын эрсдэлийг үнэлсэн тайланг хүлээн авсан бөгөөд түүнд үндэслэж 4 төрлийн эрсдэлийн дундаж үзүүлэлтийг гаргахад дараах байдалтай байна. Үүнд:





СЗХ–ноос зохицуулалтын салбарын "Комплайнсын эрсдэлийн үнэлгээ"–ний нэгдсэн тайланг гаргахаар бэлтгэл ажлыг гүйцэтгэж байна.

Комплайнс нь хууль тогтоомжийг дагаж мөрдөх, түүнд нийцүүлэн, үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг баталгаажуулдаг. Түүнчлэн, комплайнсын эрсдэлийн

үнэлгээ хийснээр нөхцөл, байдлыг тодорхойлж, эрсдэлээс урьдчилан сэргийлж, үнэлгээнд үндэслэн аливаа эрсдэлтэй үйл ажиллагаагаа олж илрүүлэх ач холбогдолтойгоос гадна эрсдэлээс сэргийлэх арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх боломжтой болно.

## ФИНТЕК БА РЕГТЕК

### ШИЛДЭГ 10: ФИНТЕК ДЕКАКОРН



#### 9. Brex

- Гүйцэтгэх захирал: Pedro Franceschi
- Орлого: £225 сая (ойролцоогоор 292 сая ам.доллар)
- Ажилтнууд: 1,545
- Үүсгэн байгуулагдсан: 2017 он

Brex нь финтек салбарт хурдацтай өсч буй компани бөгөөд £9.6 тэрбум (12.4 тэрбум ам.доллар)-ын үнэлгээнд хүрч, “Декакорн” компанийн эгнээнд багтжээ. Тус компани нь стартап болон хурдацтай өсөн нэмэгдэж буй бизнесүүдэд зориулсан өндөр лимиттэй зээлийн карт, зардал хянах, удирдах хэрэгслүүдийг санал болгосноор бизнесүүдийн санхүүг удирдах арга барилыг өөрчилсөн. Мөн хөрөнгө оруулагчдын дэмжлэгтэйгээр Brex нь £1.17 тэрбум (1.5 тэрбум ам.доллар)-ын хөрөнгө босгосон байна.

#### 8. Blockchain.com

- Гүйцэтгэх захирал: Peter Smith
- Орлого: £1 тэрбум (ойролцоогоор 1.3 тэрбум ам.доллар) (урьдчилсан)
- Төв байр: Лондон, Их Британи
- Ажилтнууд: 501–1,000
- Үүсгэн байгуулагдсан: 2011 оны 8 дугаар сар

Blockchain.com нь криптовалютын салбарт томоохон байр суурь эзэлсэн компани бөгөөд 2023 оны 11 дүгээр сарын

байдлаар £14 тэрбум (18.2 тэрбум ам.доллар)-ын үнэлгээтэй болжээ. Энэ платформ нь дэлхий даяар олон сая хэрэглэгчдэд үйлчилдэг. Одоогоор уг платформ дээр хэрэглэгчид 89 сая гаруй хэтэвч үүсгэсэн бөгөөд нийт гүйлгээний хэмжээ £800 тэрбум (1.04 их наяд ам.доллар)-ыг давсан байна.

#### 7. Rapyd

- Гүйцэтгэх захирал: Arik Shtilman
- Орлого: 1.25 тэрбум ам.доллар (урьдчилсан)
- Төв байр: Лондон, Их Британи
- Ажилтнууд: 850
- Үүсгэн байгуулагдсан: 2016 он

Rapyd нь хурдацтай өсч буй финтек компани бөгөөд 15 тэрбум ам.долларын үнэлгээтэй. Жил бүр Meta, Netflix, Uber зэрэг томоохон үйлчлүүлэгчдийнхээ төлөө 100 тэрбум ам.доллараас дээш гүйлгээ боловсруулдаг. Тус компани нь PayPal-ийн Global Payments Organisation-ийг худалдан авах зэрэг бусад бизнесийг худалдан авч үйл ажиллагаагаа өргөжүүлсэн бөгөөд одоо 100 гаруй улсад үйл ажиллагаа явуулж байна. 775 сая ам.долларын хөрөнгө оруулалт босгосон Rapyd 2026 онд олон нийтэд хувьцаагаа гаргахаар төлөвлөж байна.

#### 6. Wise

- Гүйцэтгэх захирал: Kristo Kaarmann
- Орлого: 1.1 тэрбум ам.доллар (2023 он)
- Төв байр: Лондон, Их Британи
- Ажилтнууд: 5,000+
- Үүсгэн байгуулагдсан: 2011 он

Wise нь Лондон хотод байрладаг финтек компани бөгөөд хил дамнанас шилжүүлгийн арга барилыг өөрчилсөн. Өмнө нь TransferWise нэрээрээ танигдаж байсан тус компани бага хэмжээтэй, ил тод хураамж, өрсөлдөхүйц валютын ханшаар үйлчлүүлэгчдээ татаж, уламжлалт олон улсын банкны тогтолцоог өөрчилжээ. Wise нь дэлхий даяар 13 сая гаруй хэрэглэгчтэй болсон бөгөөд 2021 онд Лондонгийн Хөрөнгийн биржид хувьцаагаа гаргаж £8 тэрбум (10.3 тэрбум ам.доллар)-ын үнэлгээнд хүрсэн байна

## 5. Klarna

- Гүйцэтгэх захирал: Sebastian Siemiatkowski
- Орлого: 1.9 тэрбум ам.доллар (2022 он)
- Төв байр: Стокгольм, Швед
- Ажилтнууд: 5,000+
- Үүсгэн байгуулагдсан: 2005 он

Klarna нь онлайн дэлгүүр хэсэхэд зориулсан “одоо худалдаж аваад, дараа төл” гэсэн төлбөрийн сонголтоороо алдаршсан. Тус компани хурдацтай өсч 2021 онд 45.6 тэрбум ам.долларын үнэлгээтэй болсон ч зах зээлийн өөрчлөлтөөс шалтгаалан 2022 онд үнэлгээ нь 6.7 тэрбум ам.доллар болж буурсан. Өнөөдөр Klarna нь дэлхий даяар 150 сая гаруй хэрэглэгчдэд үйлчилж, 500,000 гаруй жижиглэн худалдаачидтай хамтран ажиллаж байна.

## 4. Chime

- Гүйцэтгэх захирал: Chris Britt
- Орлого: Жилд 1.5 тэрбум ам.доллар
- Төв байр: Сан Франциско, АНУ
- Ажилтнууд: 1,300
- Үүсгэн байгуулагдсан: 2013 он

Chime нь АНУ-ын тэргүүлэх дижитал банкны платформ юм. 2021 онд 25 тэрбум ам.долларын үнэлгээтэй байсан ч зах зээлийн өөрчлөлтөөс шалтгаалан 8 тэрбум ам.доллар болж буурсан. Chime нь 7 сая хэрэглэгчид үйлчилж сард 8 тэрбум ам.долларын гүйлгээ боловсруулдаг. Тус компани нь үнэгүй банкны үйлчилгээ, цалинг эрт авах боломж, хүүгүй баталгаат кредит карт санал болгодог. Эдгээр онцлог нь уламжлалт банкнаас илүү хялбар сонголт хайж буй хүмүүст Chime-ийг илүү алдартай болгосон байна.

## 3. Revolut

- Гүйцэтгэх захирал: Nik Storonsky
- Орлого: 2.2 тэрбум ам.доллар (2023 он)
- Төв байр: Лондон, Их Британи
- Ажилтнууд: 10,000+
- Үүсгэн байгуулагдсан: 2015 он

Revolut нь 2015 онд Их Британид үүсгэн байгуулагдсан финтек компани бөгөөд 2021 онд 33 тэрбум ам.долларын үнэлгээтэй болсон. Энэ нь 38 улсад 25 сая гаруй хүн болон 500,000 бизнес эрхлэгчдэд үйлчилдэг. Revolut нь олон валютын данс, криптовалютын арилжаа, хувьцааны хөрөнгө оруулалт зэрэг үйлчилгээг санал болгодог. Өсөлттэй байгаа хэдий ч тус

компани 2021 оноос хойш үргэлжилж буй Их Британид банкны тусгай зөвшөөрөл авах үйл явцыг дуусгахаар ажиллаж байна.

## 2. Checkout.com

- Гүйцэтгэх захирал: Guillaume Pousaz
- Орлого: 1.1 тэрбум ам.доллар (урьдчилсан)
- Төв байр: Лондон, Их Британи
- Ажилтнууд: 1,900+
- Үүсгэн байгуулагдсан: 2012 он

Checkout.com нь 2022 онд 40 тэрбум ам.долларын үнэлгээтэй болсон дэлхийн хэмжээний төлбөрийн шийдэл нийлүүлэгч компани юм. Энэ нь томоохон бизнесүүдэд 150 валютын хүрээнд төлбөр тооцоо хийхэд нь тусалдаг ч нийт гүйлгээний тоогоо ил болгодоггүй. Guillaume Pousaz-н үүсгэн байгуулсан тус компани анх гадны хөрөнгө оруулалтгүйгээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн ч 2019 онд Европын финтек салбарт онцлох үйл явдал болсон томоохон хөрөнгө оруулалтыг татсан.

Checkout.com-ийн үйлчлүүлэгчдийн дунд Netflix, Sony зэрэг томоохон компаниуд, мөн Klarna, Revolut зэрэг финтек компаниуд багтдаг. Тус компани 19 улсад үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд криптовалютын төлбөрийн шийдэл зэрэг шинэ үйлчилгээг нэмж өргөжүүлж байна.

## 1. Stripe

- Гүйцэтгэх захирал: Patrick Collison
- Орлого: 14 тэрбум ам.доллар (2022 он)
- Төв байр: Сан Франциско, АНУ болон Дублин, Ирланд
- Ажилтнууд: 8,000+
- Үүсгэн байгуулагдсан: 2010 он

Stripe нь Patrick болон Жон John Collison нарын үүсгэн байгуулсан төлбөр тооцооны компани бөгөөд 2021 онд 95 тэрбум ам.долларын үнэлгээтэй болсон. Энэ компани жил бүр 50 улсад 600 тэрбум ам.долларын гүйлгээ боловсруулж төрөл бүрийн бизнесүүдэд үйлчилдэг. Мөн Stripe нь алдартай хувь хүмүүс болон венчур капиталын фирмүүдээс хөрөнгө оруулалт татаж чадсан.

Stripe нь зөвхөн төлбөрийн процессоор хязгаарлалгүйгээр үйлчилгээг өргөжүүлсэн. Тус компани бизнес эхлүүлэхэд туслах Stripe Atlas үйлчилгээ, мөн нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах төслүүдийг дэмжих Stripe Climate санаачилгыг нэвтрүүлсэн.

Эх сурвалж: <https://fintechmagazine.com/top10/top-10-fintech-decacorns>

## СУДЛААЧИЙН ИНДЭР

### УУР АМЬСГАЛЫН БОНДЫН СТАНДАРТ, ШААРДЛАГА: ОЛОН УЛСАД /ӨМНӨХ ДУГААРЫН СУДАЛГААНЫ ҮРГЭЛЖЛЭЛ/

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

#### Гүйцэтгэсэн:

Д.Даваамаа, СЗХ, ЗЗСХГ-ын ахлах мэргэжилтэн,  
davaamaa@frc.mn

Д.Хулан, СЗХ, ЗЗСХГ-ын мэргэжилтэн, khulan@frc.mn

### III. НОГООН/УУР АМЬСГАЛЫН БОНДЫН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

#### Маврики Улс

2016 онд Маврики Улсын Засгийн газар Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхийн тулд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс дэмжлэг хүссэн ба тус хөтөлбөрийн баг Маврики улсад төлөөлөгчийн газраа байгуулан “2030 он хүртэлх хэрэгжүүлэх тогтвортой хөгжлийн замын зураг”-ийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Энэ хүрээнд өгсөн гол зөвлөмжүүдийн нэг нь Маврики улсын ногоон санхүүжилтийн тогтолцоог бий болгож, ногоон, тогтвортой бонд зэрэг санхүүгийн шинэлэг хэрэгслийг гаргах байсан. Иймд 2021 онд Төв банк, Санхүүгийн үйлчилгээ, сайн засаглалын яам, Санхүүгийн үйлчилгээний хороо (FSC), Маврикийн хөрөнгийн бирж (SEM) болон Стандартын төлөөлөгчдөөс бүрдсэн техникийн хороог байгуулсан ба тус хороо нь Дэлхийн банк болон Францын

хөгжлийн агентлагаас чиглэл авч дотоодын тогтвортой бондын зах зээлийг хөгжүүлэх чиглэлд ажиллаж эхэлсэн. Мөн НҮБ-ын Суурин төлөөлөгчийн газар нь тус техникийн хорооны зөвлөхөөр ажилласан. Ийнхүү 2021 онд Маврики улсын тогтвортой санхүүжилтийн экосистемийн бүрэн бүтэн байдлыг хангах, бусад зүйлсийн дунд "ногоон угаалт"-аас урьдчилан сэргийлэх зорилго бүхий ногоон/тогтвортой бонд гаргахад тавигдах шаардлага, үйл явцын талаарх удирдамжийг боловсруулж олон нийтэд нийтэлсэн.

#### Бонд гаргах үйл явц

Ногоон/Тогтвортой бонд гаргах үйл явцыг гаргахаас өмнөх, гаргах, гаргасны дараах үе шат хэмээн ерөнхий ангилдаг ба тус ерөнхий үйл явцын тоймыг Хүснэгтэд харуулав.

**Хүснэгт.** Тогтвортой бонд гаргахаас өмнөх, гаргах, гаргасны дараах ерөнхий үйл явцын тойм

ҮЕ ШАТ	ГАРГАХААС ӨМНӨ	ГАРГАХ	ГАРГАСНЫ ДАРАА
АНХААРАХ	Бонд гаргагчийн ногоон бондын танилцуулга боловсруулах	Санал болгоход бэлтгэх, санал болгох	Хяналт, тайлагналт
АЛХАМ 1	Орлогын зорилтот ашиглалтын талаарх холбогдох баримт бичгийг бий болгох;	Хуулийн хүрээнд холбогдох баримт бичгийг бэлтгэх;	Орлогыг бонд гаргагчийн ногоон /нийгмийн/ тогтвортой бондын тогтолцоонд нийцүүлэн удирдах;
АЛХАМ 2	Төслийн үнэлгээ, сонгон шалгаруулалтын үйл явцыг тодорхойлох;	Санал болгох зөвшөөрөл авах;	Ногоон /нийгмийн/ тогтвортой байдлын төслүүдэд нөөцийн хуваарилалтын тайлан гаргах;
АЛХАМ 3	Орлогыг хэрхэн захиран зарцуулахыг тогтоох;	Саналыг нээх;	Бонд гаргагч нь ногоон /нийгмийн/ тогтвортой байдлын төслүүдийн төлөв байдлын шинэчлэлтийг өгөхийн тулд холбогдох гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (KPI)-ийн талаар тайлагнаж болно.
АЛХАМ 4	Хөндлөнгийн үнэлгээ хийх.	Санал түгээх, хуваарилах	

Эх сурвалж: Guide for the issue of sustainable bonds in Mauritius (2021)

**Гаргахаас өмнөх үе шат:**

*Бонд гаргагчийн ногоон/нийгмийн/тогтвортой бондын бодлогын баримт бичгийг бий болгох:*

Ногоон/ Тогтвортой бондын хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхийн тулд засаглал, ил тод байдлыг, ялангуяа “ногоон” / “нийгмийн” / “тогтвортой байдал” тал дээр илүү анхаарах хэрэгтэй ба ногоон бонд гаргах үйл явц нь энгийн бондын үйл явцтай төстэй.

**Тогтвортой бондыг гаргах алхмууд:**

1. Ногоон / Нийгмийн / Тогтвортой байдлын бондын бодлогын баримт бичгийг бий болгох;
2. Хөндлөнгийн хяналт шалгалт хийх;
3. Бондоо зах зээлд гаргах.

Ногоон/ ТоХ–д чиглэсэн бонд гаргагчид юуны өмнө санхүүжүүлэх төслийн төрөл, орлогын ашиглалт, орлогын удирдлага, бонд гаргагчийн тайлагнах үйл явцыг нарийвчлан тусгасан баримт бичгийн төсөл буюу бондын хүрээний төслийг боловсруулах шаардлагатай.

Ногоон бондын хувьд бонд гаргагчид нь ICMA–аас гаргасан Ногоон бондын зарчим, Уур амьсгалын бондын стандарт, ангилал зүй болон бусад тогтоосон стандарттай нийцүүлэх шаардлагатай. Ногоон бондын зарчим болон Уур амьсгалын бондын санаачилгаас гаргасан ангилал зүйд нийцсэн ногоон төслүүдэд хамрагдах хэд хэдэн өргөн ангилал байдаг бөгөөд үүнд:

- Сэргээгдэх эрчим хүч;
- Эрчим хүчний хэмнэлт;
- Бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах;
- Амьд байгалийн баялаг, газар ашиглалтын байгаль орчинд ээлтэй тогтвортой менежмент;
- Газрын болон усны биологийн олон янз байдлыг хамгаалах;
- Тээвэрлэлт;
- Ус, усны тогтвортой менежмент;
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох;

- Эко хэмнэлттэй эсвэл тойрог эдийн засагт тохирсон бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн технологи, үйл явц;
- Бүс нутаг, үндэсний болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, гэрчилгээг хангасан ногоон байгууламж.

Тодорхой үйл ажиллагааг дэмжих эсвэл сурталчлах дараах төслүүдийг ногоон/ ТоХ–д чиглэсэн өрийн хэрэгслээр санхүүжүүлэхийг хориглоно. Үүнд:

- Газрын тосны хайгуул, олборлолт;
- Зэвсэг, сумны үйлдвэрлэл, худалдаа;
- Согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа;
- Тамхины үйлдвэрлэл, худалдаа;
- Мөрийтэй тоглоом, казино болон түүнтэй адилтгах аж ахуйн нэгжүүд;
- Цацраг идэвхт бодис үйлдвэрлэх, худалдаалах (энэ нь эмийн худалдан авалтад хамаарахгүй);
- Албадан хөдөлмөр/хүүхдийн хор хөнөөлтэй хөдөлмөрийн хор уршигтай, мөлжлөгийн хэлбэр бүхий үйлдвэрлэл, үйл ажиллагаа;
- Тогтвортой менежменттэй ойгоос бусад мод болон ойн бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдаалах;
- Үндэсний хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын конвенци, хэлэлцээрийн дагуу хууль бус гэж тооцогдсон аливаа бүтээгдэхүүн, үйл ажиллагааг үйлдвэрлэх, худалдаалах.

Дээр дурдсанчлан бондын танилцуулга, бодлогын баримт бичигт дараах үндсэн 4 зарчим заавал тусгагдсан байх ёстой(Хүснэгт).

**Хүснэгт.** Мавраки улсын ногоон/ тогтвортой бондын хүрээний үндсэн 4 зарчим

ЗАРЧИМ	ТОДОРХОЙЛОЛТ
1.ОРЛОГЫГ АШИГЛАХ	<ul style="list-style-type: none"> <li>• Бондын орлогыг Ногоон/Нийгмийн төслүүдийг санхүүжүүлэх эсвэл дахин санхүүжүүлэхэд ашиглах бөгөөд үүнийг зохицуулагч байгууллагад хүргүүлэх эрх зүйн баримт бичигт зохих ёсоор тайлбарласан байх ёстой.</li> <li>• Бүх сонгогдсон ногоон төслүүд нь байгаль орчны тодорхой үр өгөөжийг өгөх ёстой бөгөөд боломжтой бол бонд гаргагч тоон үзүүлэлтээр тооцож, тодруулга хийх.</li> <li>• Ногоон/Нийгмийн ямар төсөл, хөрөнгө, арга хэмжээг санхүүжүүлэх, санхүүжилтийг хэрхэн удирдаж, хуваарилахаа тодорхойлж, ил тод болгох шаардлагатай.</li> <li>• Ногоон төслүүд аль тогтвортой хөгжлийн зорилтод хэрхэн хувь нэмэр оруулж буйг олон нийтэд мэдээлэх.</li> </ul>
2.ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ	<p>Бонд гаргагч нь бонд гаргахаас өмнө дараах мэдээллийг Санхүүгийн зохицуулагч байгууллага, хөрөнгө оруулагчид болон Үнэт цаасны биржид нээлттэй мэдээлэх ёстой:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Санал болгож буй төслийг шаардлага хангасан эсэхийг үнэлэх эсхүл Ногоон/Нийгмийн төсөл хэрхэн ангилж байгааг үнэлэх дотоод үйл явц;</li> <li>• Санал болгож буй төслийн байгаль орчны / нийгмийн хүлээгдэж буй үр өгөөж;</li> <li>• Санал болгож буй төслийг сонгох, батлахтай холбоотой дотоод үйл явц;</li> <li>• Санал болгож буй төсөлд иш татсан аливаа стандарт, гэрчилгээ;</li> <li>• Хүрээлэн буй орчин/нийгмийн болзошгүй эрсдэлийг тодорхойлох үйл явц.</li> </ul> <p>Тогтвортой бондын баримт бичигт ашигласан аливаа стандарт, гэрчилгээ, хөндлөнгийн шалгалтын үр дүнг тодорхой тусгагдсан байх ёстой.</p>
3.ОРЛОГЫН МЕНЕЖМЕНТ	<p>Бонд гаргагч нь өөрийн чадавхын хэрээр орлогыг хэрхэн удирдах үйл явцыг тодорхой тайлбарлах ёстой:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бондын орлогыг дэд данс нээж байршуулах;</li> <li>• Ногоон бондын эх үүсвэрээр зээл олгох болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулахтай холбоотой албан ёсны дотоод журам баталж мөрдөх;</li> <li>• бондын үлдэгдэлтэй байгаа тохиолдолд бонд гаргагч ногоон дансыг төслийн зардалтай тулгалт хийж, хуваарилагдаагүй үлдэгдлийг хэрхэн байршуулж байгаа талаар хөрөнгө оруулагчдад мэдэгдэх.</li> </ul> <p>Дотоод хяналт, хуваарилалтын үйл явцыг шалгахын тулд аудитор эсвэл гуравдагч этгээдээр хөндлөнгийн хяналт хийлгэх хэрэгтэй.</p>
4. ТАЙЛАГНАХ	<p>Бонд гаргагч шаардлага хангасан ямар ямар төслүүдэд орлогыг хуваарилсан тухай тайлагнах шаардлагатай. Энэ нь ихэвчлэн жилийн тайланд тусгагдаж болох бөгөөд зохих төслүүдийн жагсаалтыг гаргаж, төслүүдийн товч тайлбарыг өгч, холбогдох хуваарилалтыг зааж өгнө. Мөн орлого хуваарилалтын ил тод байдал, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхийн тулд илүү олон удаа тогтмол тайлан гаргаж болно. Тухайлбал орлогын ашиглалтын тайлан, аудит/баталгаажуулалтын тайлан, ESG/тогтвортой байдлын тайланд тусгаж болно.</p>

**Гаргасны дараах үе шат:***Хөндлөнгийн хяналт, баталгаажуулалт*

Хөндлөнгийн хяналт, баталгаажуулалтын хувьд тогтвортой бонд гаргахтай холбогдуулан бонд гаргагчид байгаль орчны тогтвортой байдал болон тогтвортой бонд гаргах бусад асуудлаар хүлээн зөвшөөрөгдсөн хөндлөнгийн хяналтын үйлчилгээ үзүүлэгчийг томилохыг зөвлөдөг. Хөндлөнгийн хяналтын үйлчилгээ үзүүлэгч нь бонд гаргагчаас хараат бус байх ёстой. Түүнчлэн, Хөндлөнгийн хяналтын үйлчилгээ үзүүлэгч нь Санхүүгийн зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл авсан эсхүл бүртгүүлсэн байх ёстой.

Хөндлөнгийн хяналт шалгалтын төрлөөс хамааран хөндлөнгийн шинжээчид дараах зүйлийг хийнэ:

- Ногоон ба/эсвэл Нийгмийн бондын төслийн шалгуур үзүүлэлтийн чиглэлээр мэргэшсэн байх ба шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэх талаар дүгнэлт өгөх;
- Тогтвортой бондын хөрөнгөөр санхүүжүүлж буй ногоон/нийгмийн төслүүдийн байгаль орчны / нийгмийн үр ашиг, нөлөөллийг үнэлэх;
- Ногоон\ Нийгмийн бондын зарчмууд үндсэн дөрвөн бүрэлдэхүүн хэсэгтэй нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах/хянах;
- Бонд гаргагчийн тодорхойлсон Төслүүдтэй холбоотой байгаль орчны /нийгэмд учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх;
- Хяналтын тайландаа бонд гаргагчаас хараат бус ажиллах боломжтой эсэхээ тусгах.

**Кени Улс**

Кени Улсын Найроби үнэт цаасны бирж нь 2019 онд Тогтвортой санхүүжилтийн санаачилга, Уур амьсгалын бондын санаачилга, Кенийн банкнуудын холбоо, Голландын бизнес эрхлэгчдийн хөгжлийн банк зэрэг байгууллагуудын тусламжтайгаар Ногоон бонд хөтөлбөрийн хүрээнд ногоон бондын удирдамжийг гаргасан. Тус удирдамж нь Кени улсад ногоон бондын тогтолцоог бүрдүүлж, татан төвлөрүүлсэн бондын орлогыг байгаль орчинд ээлтэй төслүүдэд зарцуулах, энэхүү процессын ил тод, хариуцлагатай байдлыг баталгаажуулах зорилготой юм.

Кени улсад ногоон бонд гаргах процесс нь нийт 6 үе шаттай:

1. Шаардлага хангасан ногоон төсөл, хөрөнгийг тодорхойлох;
2. Бонд гаргагч ногоон бондын танилцуулга холбогдох бодлогын баримт бичгийг боловсруулах;
3. Баталгаажуулалт хийлгэх;
4. Хяналт, тайлагнал;
5. Бондоо гаргах;

Орлогын ашиглалтад хяналт тавих, жил бүр тайлагнах.

**Алхам 1: Орлого ашиглалт буюу шаардлага хангасан ногоон төсөл, хөрөнгийг тодорхойлох.**

Найроби үнэт цаасны биржээс гаргасан удирдамжийн дагуу ногоон бондоос гаргасан төслүүд нь олон улсын Ногоон бондын зарчим, Уур амьсгалын бондын ангилал зүй болон Уур амьсгалын санхүүжилтийн үндэсний бодлого зэрэг бусад үндэсний ногоон стратеги, бодлогод тодорхойлсон ангилалд багтсан байна.

Уур амьсгалын бондын стандартын салбарын шалгуурууд нь төсөл, хөрөнгийн биелүүлэх ёстой тодорхой шаардлага, босгыг тодорхойлсон байдаг. Иймд шаардлага хангасан хөрөнгө, төслийг тодорхойлохын тулд байгууллага доторх санхүү болон байгаль орчны алба нягт хамтран ажиллах шаардлагатай.

**Алхам 2: Ногоон бондын бодлогын баримт бичгийг боловсруулах.**

Ногоон бондын бодлогын баримт бичигт төсөл, хөрөнгийн зохистой байдлыг тодорхойлоход ашиглах дотоод шийдвэр гаргах үйл явцыг тусган, баримтжуулж хадгалах ёстой. Ногоон бондын хүрээний бүтцэд дараах хүснэгтэд тусгасан дөрвөн үндсэн зарчмыг заавал тусгана.

**Хүснэгт. Кени Улсын ногоон/ тогтвортой гаргах үндсэн 4 зарчим**

ЗАРЧИМ	ТОДОРХОЙЛОЛТ
1.ОРЛОГЫГ АШИГЛАХ	Орлогыг ногоон төслүүдийг санхүүжүүлэх эсвэл дахин санхүүжүүлэхэд зарцуулах ба бонд гаргагч ногоон төслийн шалгуурыг бүрэн тодорхойлж тусгах;
2.ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ	Энэ хэсэгт ногоон төслийг сонгоход шаардлагатай процесс, засаглалын механизмуудын талаар дурдана. Тухайлбал, ихэнх Бонд гаргагчид газар, хэлтэсийн ахлахуудаас бүрдсэн Сонгон шалгаруулалтын хороог байгуулдаг. Тус хороо нь төсөл, хөрөнгийг сонгон шалгаруулах зөвлөмжийг гаргах ба батлуулахаар Удирдах зөвлөлд хүргүүлдэг. Бонд гаргагч бүр үндсэн төсөл, хөрөнгийг сонгох өөр өөр арга замтай байж болох ч сонгон шалгаруулалтын процессыг аль болох ил тод байлгах ёстой.
3.ОРЛОГЫН МЕНЕЖМЕНТ	Тус хэсэгт орлогыг дотооддоо удирдах, хянах зорилгоор бонд гаргагчийн авч хэрэгжүүлэх механизмуудыг тодорхойлно. Тухайлбал, бондын сан, хөрөнгө оруулалтыг удирдахад ашиглах систем, бодлого, мөн орлогыг хянах, хуваарилагдаагүй орлогыг удирдах зохицуулалт орно.
4. ТАЙЛАГНАХ	Бонд гаргагч нь бонд эзэмшигчдэд жилд хамгийн багадаа нэг удаа бондын хугацаанд орлого хуваарилсан төсөл, хөрөнгийн жагсаалтыг агуулсан Ногоон бондын тайланг гаргана. Уг тайланд төслүүдийн нөлөөллийн гүйцэтгэлийн тоон үзүүлэлтүүдийг оруулж болно.  Нууцлалын тухай гэрээ эсвэл өрсөлдөөний асуудал нь задруулах дэлгэрэнгүй мэдээллийг хязгаарласан тохиолдолд мэдээллийг ерөнхий байдлаар танилцуулах боломжтой.

*Эх сурвалж: NSE, Kenya Green Bond Guidelines Background Document*

**Алхам 3: Хөндлөнгийн хяналт, баталгаажуулалт**

Найроби үнэт цаасны биржийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.13.1–д “Эрх олгох бонд гаргагч нь санхүүжүүлэх төслүүдийг Ногоон стандарт, удирдамжийн дагуу үнэхээр ногоон гэж ангилсан байх эсэх болон Ногоон бондын тогтолцооны дагуу төслийг сонгох, санхүүжилтийг хянах дотоод үйл явц, журам зэргийг баталгаажуулах бие даасан шалгагчийг томилно” гэж заасан байдаг. Үүний дагуу тус шалгалтыг ихэвчлэн байгаль орчны мэдээллийн томоохон баазтай байгууллагууд хийдэг. Тус байгууллага нь ногоон бондод бие даасан үнэлгээ хийх үүрэг хүлээдэг ба бонд гаргахаас өмнө баталгаажуулалтын тайланг (хөндлөнгийн хяналт гэж нэрлэдэг) гаргадаг. Ногоон бондын хөндлөнгийн хяналт нь дараах хоёр ангиллын аль нэгэнд багтаж болно.

*Хоёрдогч талын санал бодол:* Энэ нь Ногоон бонд болон тэдгээрийн суурь төсөл, хөрөнгийн тогтвортой байдлын талаарх бие даасан, судалгаанд суурилсан үнэлгээ бөгөөд ихэвчлэн Ногоон бондын зарчимд хэр нийцтэй байгааг шалгана. Хоёрдогч талын саналын дүгнэлтийг ихэвчлэн бонд гаргахаас өмнө гаргадаг.

*1 Тус бонд нь ногоон бондын шаардлагыг хангаж байгааг илэрхийлсэн гэдгийг нотолсон баримт бичиг.*

*Баталгаажуулалтын тайлан:* НББОУС 3000–д тодорхойлогдсон процессын дагуу хийгддэг бие даасан аудит бөгөөд энэ нь санхүүгийн бус түүхэн мэдээллийг боловсруулахад нягтлан бодогчдын ашигладаг стандарт юм. Баталгаажуулалтын саналууд нь бондын ногоон итгэмжлэл<sup>1</sup>, Бонд гаргагчийн тогтоосон дотоод журмын аль алинд нь үнэлгээ хийдэг.

Баталгаажуулагч нь бондын ногоон гэдгийг баталгаажуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг тул Найроби үнэт цаасны биржийн дүрэмд бие даасан баталгаажуулагчид тавигдах ерөнхий шаардлагыг тусгасан байдаг ба тус баталгаажуулалтыг Уур амьсгалын стандарт ба гэрчилгээжүүлэлтийн схем, эсвэл Найроби үнэт цаасны биржид бүртгэлтэй байгууллага хийдэг. Баталгаажуулагч нь Найроби үнэт цаасны биржээс зохион байгуулдаг сургалтад заавал хамрагдах ёстой.

**Алхам 4: Орлогын менежмент – Хяналт, тайлагналыг тохируулах.**

Ногоон бондын орлого хуваарилалтын талаарх мэдээллийг хөрөнгө оруулагчдад өгөх шаардлагатай ба үүнд дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй:

- Ногоон бондын орлогыг зөвхөн ногоон төсөлд зарцуулах ёстой тул ногоон бондын орлогыг ялгаж, зарцуулалтыг нь бүртгэх системтэй байх ёстой.
- Хөрөнгийн сан эсвэл төслийн нэрлэсэн үнэ нь бондын дүнтэй тэнцүү буюу түүнээс их байх ёстой.
- Ногоон бондын ашиглалтын хугацаанд орлогыг ногоон бус хөрөнгө оруулалтад хэзээ ч санаатайгаар байршуулахгүй байхын тулд хяналтын журмыг бий болгох ёстой.

Цаашлаад, орлогын менежментийн үйл явцыг тодорхойлохдоо бонд гаргагч нь хуваарилагдаагүй орлогыг хэрхэн удирдахаа шийдэх хэрэгтэй. Төсөл, хөрөнгөд хуваарилагдаагүй орлогын үлдэгдлийг богино хугацаат аливаа хөрөнгө оруулалт, хадгаламж болон бусад богино хугацаат хөрвөх чадварын хэрэгсэлд байршуулах ёстой ба орлогыг Ногоон бондын зарчмууд болон Уур амьсгалын бондын стандартад заасны дагуу 24 сараас илүү хугацаагаар хуваарилахгүй үлдээж болохгүй.

#### Алхам 5: Ногоон бонд гаргах.

Ногоон бондыг ердийн бондын адилаар гаргадаг. Санхүүгийн зохицуулагч байгууллага, Найробигийн үнэт цаасны бирж зэрэг зохицуулагч байгууллагуудаас Ногоон бондын гаргах зөвшөөрөл авдаг. Ингэхдээ Найробигийн үнэт цаасны бирж бүртгэлийн дүрмийн 2.14–д заасны дагуу дараах нэмэлт мэдээллийг хүргүүлнэ.

- Ногоон бондын байгаль орчны зорилтууд болон төслийн шаардлага, холбогдох шалгууруудыг тодорхойлох үйл явцын тухай мэдэгдэл;
- Бондын хөрөнгө, хөрөнгө оруулалтыг удирдах, хуваарилах, тайлагнахад ашиглах систем, бодлого, үйл явцын тухай мэдэгдэл;
- Гэрээт бие даасан баталгаажуулагчийн талаарх мэдээлэл;
- Санхүүжүүлэх төслүүд нь ногоон гэсэн шалгуурыг хангасан болохыг баталгаажуулсан тайлан;
- Ногоон бондын зах зээл, үнийн талаарх мэдээлэл.

Бондын зэрэглэлийг бусад бондтой адил үнэлдэг.

#### Алхам 6: Тогтмол мэдээлэх (жил бүр)

Бондын тайлан, үйл явцыг мэдээлэх процесс нь хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалт болон үндсэн төсөл, хөрөнгийн байгаль орчны гүйцэтгэл хоорондын шууд холбоог бий болгодог учраас чухал байдаг.

Үндэсний хөрөнгийн биржийн дүрмийн 2–р хэсэгт заасны дагуу Бонд гаргагч нь Санхүүгийн зохицуулагч байгууллага, Үндэсний хөрөнгийн бирж болон хөрөнгө оруулагчдад хамгийн багадаа жилд нэг удаа бонд, хөрөнгө ногоон төслүүдэд зохих ёсоор хуваарилагдсан талаарх мэдээллийг гаргаж өгөх ба бонд гаргагчийн вэбсайтаар дамжуулан ил тод болгох ёстой. Бонд гаргагч нь хөрөнгө оруулагчид болон зохицуулагчид дор хаяж жилд нэг удаа тайлагнадаг байх ёстой боловч зарим Бонд гаргагчид жил бүр, бүр улирал бүр тайлагнаж болно. Тайланд дараах мэдээлэл заавал тусгагдсан байна:

- Аливаа төслийн тодорхойлолт, олгосон хөрөнгийн хэмжээ, түүний дотор төслийн төрөл, санхүүжилт, дахин санхүүжилтэд хуваарилагдсан орлогын хувь хэмжээ;
- Ногоон төсөл, хөрөнгөд гарсан аливаа томоохон өөрчлөлт;
- Төслүүд нь тодорхойлсон шаардлагад нийцэхгүй болсон тохиолдолд бонд гаргагч нь орлогыг төсөлд дахин хуваарилсан эсэх;
- Хуваарилагдаагүй орлогын нийт үлдэгдэл, тэдгээрийг хэрхэн хадгалж байгаа талаар, түүнчлэн хуваарилагдаагүй орлогыг нүүрстөрөгчийн эрчимжсэн төслүүдийг санхүүжүүлэхэд зориулаагүй гэсэн баталгааг багтаах;
- Ногоон төслийн байгаль орчны гүйцэтгэлийн чанарын болон тоон үзүүлэлтүүд.

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү судалгаагаар уур амьсгалын өрийн хэрэгслийн олон улсын стандарт, холбогдох баримт бичгүүд болон Кени, Мавраки улсын ногоон/уур амьсгалын бондын сайн туршлагыг судаллаа.

Олон улсад ногоон/ уур амьсгалын бонд гаргахтай холбоотой Ногоон бондын зарчмууд, Уур амьсгалын бондын стандарт зэрэг баримт бичгийг түгээмэл ашиглаж байна. Ногоон бондын зарчмууд нь зах зээлд ногоон бонд гаргах замыг тодорхой болгох, зах зээлийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, шударга байдлыг дэмжих зорилготой. Энэхүү удирдамж нь орлогын ашиглалт, төслийн үнэлгээ, сонгон шалгаруулалтын үйл явц, орлогын менежмент болон тайлагнах гэсэн үндсэн дөрвөн хэсгээс бүрддэг ба эдгээр нь уур амьсгалын бондын стандартын суурь болдог. Уур амьсгалын бондын стандарт нь ногоон бонд болон бусад өрийн хэрэгсэлд итгэх хөрөнгө оруулагчийн итгэлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулжээ.

Олон улсын туршлагаас авч үзвэл Кени Улсын хувьд 2019 онд ногоон бондын удирдамжаа гаргасан бол Маврики Улс нь Дэлхийн банк болон Францын хөгжлийн агентлаг, НҮБ-ын дэмжлэгтэйгээр 2021 онд Ногоон бонд гаргагчдад зориулсан гарын авлагыг гаргажээ. Маврики Улсын удирдамжид Ногоон/Тогтвортой бонд гаргах үйл явцыг гаргахаас өмнөх, гаргах, гаргасны дараах үе шат хэмээн ерөнхий ангилсан бөгөөд бонд гаргах алхмууд болон ногоон бондоор санхүүжүүлэх болон санхүүжүүлэх боломжгүй төслүүдийн жагсаалт, ногоон бондын төрөл бүрийн хангах холбогдох стандартуудыг тодорхойлжээ. Мөн мэргэжлийн хөндлөнгийн байгууллагын баримтлах 5 үндсэн зарчим, хөндлөнгийн баталгаажуулалтын хэд хэдэн хэлбэрүүдийг санал болгосон. Харин Кени Улсын хувьд ногоон бонд гаргах 6 алхам байдаг бөгөөд алхам тус бүрд холбогдох шаардлагуудыг нарийн тодорхойлсон байна.

Ийнхүү ногоон/ уур амьсгалын бондын олон улсын зохицуулалтын туршлагад үндэслэн цаашид Ногоон/ Уур амьсгалын бонд гаргах процессыг тодорхой болгох, зах зээлийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор ногоон/ тогтвортой бондын удирдамжийг боловсруулах, холбогдох зохицуулалтыг өрийн хэрэгсэл бүртгэх журамд нэмж тусгах боломжтой байна. Ийнхүү ногоон бондын удирдамж, зохицуулалтад дараах шаардлагуудыг нэмж тусгах саналыг боловсрууллаа:

- Ногоон бондын танилцуулга, бодлогын баримт бичигт заавал тусгах мэдээлэл, тавигдах шаардлага;
- Бондын зарцуулалтын ил тод байдлыг хангах үүднээс тодорхой давтамжтайгаар хөрөнгө оруулагчдад мэдээлэх тайлангийн бүрэлдэхүүн хэсэг, түүнд заавал тусгасан байх ёстой мэдээллийн жагсаалт;
- Бонд гаргагчид бондын орлогын 95-аас доошгүй хувийг Салбарын ангилал зүйн шалгуурыг хангасан төсөл, хөрөнгөд хуваарилсан байхыг шаардах ба хэрэв салбарын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаагүй төсөл, хөрөнгийг санхүүжүүлсэн тохиолдолд бонд гаргагч нь ногоон бондын бодлогын баримт бичигт дэлгэрэнгүй тодруулга өгөх талаарх зохицуулалт;
- Салбарын шалгуурыг бүрэн хангаагүй аливаа төсөл, хөрөнгөд тавигдах ерөнхий шаардлага;
- Бонд гаргагчийн бондын орлогыг хуваарилж дуусах хугацааг тодорхойлон орлогын дахин хуваарлалт, хуваарилагдаагүй орлогыг богино хугацаат хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх талаарх зохицуулалт;
- Бонд гаргагчийн төсөл сонгон шалгаруулах шийдвэр гаргах үйл явц, төсөл, хөрөнгөд орлого хуваарилах процессыг баримтжуулж, хөтлөх талаарх зохицуулалт.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Bank of Mauritius (2021), Guide for the issue of sustainable bonds in Mauritius. Available at: [https://www.bom.mu/sites/default/files/guide\\_sustainable\\_bonds\\_final\\_-\\_7\\_june\\_2021.pdf](https://www.bom.mu/sites/default/files/guide_sustainable_bonds_final_-_7_june_2021.pdf)
- Climate Bond Initiative (2024), Climate Bonds Standard V4.2. Available at: <https://www.climatebonds.net/climate-bonds-standard-v42>
- Financial Services Agency (2021), Basic Guidelines on Climate Transition Finance, available at: <https://www.meti.go.jp/press/2021/05/20210507001/20210507001-3.pdf>
- ICMA (2021), Green Bond Principles: Voluntary Process Guidelines for Issuing Green Bonds. Available at: <https://www.icmagroup.org/assets/documents/Sustainable-finance/2022-updates/Green-Bond-Principles-June-2022-060623.pdf>
- ICMA (2023), Climate Transition Finance Handbook: Guidance for Issuers. Available at: <https://www.icmagroup.org/assets/documents/Sustainable-finance/2023-updates/Climate-Transition-Finance-Handbook-CTFH-June-2023-220623v2.pdf>
- NSE(2018), Kenya Green Bond Guidelines Background Document. Available at: <https://www.nse.co.ke/wp-content/uploads/gbpk-background-document-2.pdf>
- Sovereign Sustainable Finance Committee (2023), Brazil's Sovereign Sustainable Bond Framework. Available at: [https://sisweb.tesouro.gov.br/apex/f?p=2501:9:::9:P9\\_ID\\_PUBLICACAO\\_ANEXO:21043](https://sisweb.tesouro.gov.br/apex/f?p=2501:9:::9:P9_ID_PUBLICACAO_ANEXO:21043)
- The National Treasury Kenya (2021), Kenya sovereign green bond framework. Available at: <https://www.fsdafrica.org/wp-content/uploads/2021/06/Kenya-Sovereign-Green-Bond-Framework.pdf>
- UNDP (2023), Уур амьсгалын өөрчлөлтийн толь бичиг. Эх үүсвэр: <https://www.undp.org/mn/mongolia/news/uur-ams-galyn-oorcholtiyn-tol-bichig-uur-amsgalyn-oorcholtiyn-asuudlaarkh-odor-tutmyn-garyn-avlaga>
- World bank (2021), What You Need to Know About IFC's Green Bonds. Available at: <https://www.worldbank.org/en/news/feature/2021/12/08/what-you-need-to-know-about-ifc-s-green-bonds>.
- Bank of Mauritius (2021), Guide for the issue of sustainable bonds in Mauritius. Available at: [https://www.bom.mu/sites/default/files/guide\\_sustainable\\_bonds\\_final\\_-\\_7\\_june\\_2021.pdf](https://www.bom.mu/sites/default/files/guide_sustainable_bonds_final_-_7_june_2021.pdf)
- Climate Bond Initiative (2024), Climate Bonds Standard V4.2. Available at: <https://www.climatebonds.net/climate-bonds-standard-v42>
- Financial Services Agency (2021), Basic Guidelines on Climate Transition Finance, available at: <https://www.meti.go.jp/press/2021/05/20210507001/20210507001-3.pdf>
- ICMA (2021), Green Bond Principles: Voluntary Process Guidelines for Issuing Green Bonds. Available at: <https://www.icmagroup.org/assets/documents/Sustainable-finance/2022-updates/Green-Bond-Principles-June-2022-060623.pdf>
- ICMA (2023), Climate Transition Finance Handbook: Guidance for Issuers. Available at: <https://www.icmagroup.org/assets/documents/Sustainable-finance/2023-updates/Climate-Transition-Finance-Handbook-CTFH-June-2023-220623v2.pdf>
- NSE(2018), Kenya Green Bond Guidelines Background Document. Available at: <https://www.nse.co.ke/wp-content/uploads/gbpk-background-document-2.pdf>
- Sovereign Sustainable Finance Committee (2023), Brazil's Sovereign Sustainable Bond Framework. Available at: [https://sisweb.tesouro.gov.br/apex/f?p=2501:9:::9:P9\\_ID\\_PUBLICACAO\\_ANEXO:21043](https://sisweb.tesouro.gov.br/apex/f?p=2501:9:::9:P9_ID_PUBLICACAO_ANEXO:21043)
- The National Treasury Kenya (2021), Kenya sovereign green bond framework. Available at: <https://www.fsdafrica.org/wp-content/uploads/2021/06/Kenya-Sovereign-Green-Bond-Framework.pdf>
- UNDP (2023), Уур амьсгалын өөрчлөлтийн толь бичиг. Эх үүсвэр: <https://www.undp.org/mn/mongolia/news/uur-ams-galyn-oorcholtiyn-tol-bichig-uur-amsgalyn-oorcholtiyn-asuudlaarkh-odor-tutmyn-garyn-avlaga>
- World bank (2021), What You Need to Know About IFC's Green Bonds. Available at: <https://www.worldbank.org/en/news/feature/2021/12/08/what-you-need-to-know-about-ifc-s-green-bonds>.

**САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО**

**Цуврал №44**

*Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг санжруулах хөтөлбөрийн хүрээнд*

## Хамтын санхүүжилт гэж юу вэ?

**Crowdfunding** буюу **хамтын санхүүжилт** гэдэг нь олон нийтээс хөрөнгө оруулалт босгох замаар иргэн, ААН-ийн тодорхой төсөл, бизнес, эсхүл бүтээгдэхүүнийг санхүүжүүлэх үйл явц юм.



**Төсөл хэрэгжүүлэгч**

Төсөл оруулах,  
танилцуулах



Хөрөнгө оруулах



**Санхүүжилт олгогч**

### Хамтын санхүүжилтийн төрлүүд

- 01

**Хандив**

Нийгэмд хэрэгцээтэй төслүүдийг дэмжих боломжийг олгодог бөгөөд сайн дурын үндсэн дээрээс эргэж төлөгдөхгүй санхүүжилт оруулдаг.
- 02

**Урамшуулалт**

бүтээгдэхүүн, үйлчилгээ эсвэл бусад хэлбэрийн урамшуулал санал болгох замаар хөрөнгө оруулалт татдаг.
- 03

**Хувьцаа**

Олон нийтээс хөрөнгө босгох замаар хувьцаа эзэмших эрхийг санал болгож, төслийг эсвэл бизнесийг санхүүжүүлдэг.
- 04

**Зээл**

Хөрөнгө оруулагчид төсөлд тодорхой хэмжээний мөнгө зээлж, төсөл амжилттай хэрэгжиж эхлэхэд хүү болон үндсэн зээлийг буцаан авдаг.


ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

Цуврал №44


### Дэлхийн хамтын санхүүжилтийн зах зээл



Spherical Insights & Consulting компанийн нийтэлсэн судалгааны тайлан

Дэлхийн хамтын санхүүжилтийн зах зээлийн хэмжээ **2023 онд 1.2 тэрбум ам.доллар** байсан бол 2033 он гэхэд 4.4 тэрбум ам.доллар болж, **жилийн нийлмэл өсөлтийн хурдыг 14.0%** байхаар тооцоолж байна.

Compound Annual Growth Rate, CAGR



#### Хамтын санхүүжилтын давуу болон сул тал

##### Давуу тал:

- ✓ Санхүүжилт авах боломж нэмэгддэг;
- ✓ Олон нийтэд танигдах боломж өсдөг;
- ✓ Хөрөнгө оруулах болон татахад хялбар.

##### Сул тал:

- ✗ Төсөл амжилттай хэрэгжихэд цаг хугацаа, нөөц шаарддаг;
- ✗ Төсөл хэрэгжүүлэгч талаас эрсдэл болон асуудал үүсэх боломжтой;
- ✗ Өрсөлдөөн ихтэй.

Дэлхийн тэргүүлэгч  
Хамтын санхүүжилтын  
платф ормууд

**INDIEGOGO.**


**KICKSTARTER**

**gofundme™**

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### БИТКОЙНЫ ХАНШ ТҮҮХЭН ДЭЭД ТҮВШНЭЭС ДАВЖ 100,000 АМ.ДОЛЛАРТ ХҮРЭВ.



Криптовалютын зах зээлийн хамгийн өндөр өсөлттэй криптовалютаар биткойн тодорлоо. Энэхүү өсөлт нь олон хүчин зүйлээс шалтгаалж байгаа ч өсөлтөд нөлөөлсөн

хамгийн чухал хүчин зүйл нь АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Дональд Трампын өгсөн криптовалютын зах зээлийг хөгжүүлэх, зохицуулалтын орчныг бий болгох амлалтууд байна.

Биткойн ханш 12 дугаар сарын 05-ны өдөр 6.1 хувиар өсөж 103,800 ам.долларт хүрсэн нь АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд 11 дүгээр сард Дональд Трамп ялалт байгуулснаас хойш 50 гаруй хувиар өсжээ. 2022 оны сүүлээр криптовалютын арилжааны бирж FTX дампуурлаа зарласнаар биткойны үнэ 16,000 ам.долларт хүрсэн бол 2 жилийн өмнөхтэй харьцуулахад биткойны үнэ 100,000 ам.долларт хүрсэн нь энэ салбарын хөрөнгө өндөр өсөлттэй байгааг харуулж байна.

Эх сурвалж: [www.ft.com](http://www.ft.com)

### АНУ-ЫН 30 ЖИЛИЙН ХУГАЦААТАЙ МОРГЕЙЖИЙН ЗЭЭЛИЙН ХҮҮ 6.6 ХУВЬ БОЛЖ БУУРЛАА.



АНУ-ын 30 жилийн хугацаатай моргейжийн зээлийн дундаж хүү 3-н долоо хоног дараалан буурч 6.69 хувиас 6.60 хувьд хүрчээ. Энэ нь моргейжийн

зээлийн дундаж хүү хамгийн доод түвшинд хүрсэн үзүүлэлт юм. Моргейжийн зээлийн хүү өмнөх оны мөн үед 6.95 хувь байжээ.

Моргейжийн зээлийн хүү буурсан гол шалтгаан нь хөрөнгийн зах зээл идэвхжиж, хэрэглэгчийн орлого тогтвортой өссөнөөр хэрэглэгчийн эрэлт, орон сууцны борлуулалтыг нэмэгдүүлжээ. АНУ-ын үл хөдлөх хөрөнгийн хамгийн том агентлаг болох "Friedrich Mac" -ын ахлах эдийн засагч Сэм Хатерийн дүгнэж байгаагаар "Орон сууцны зах зээлийн хэтийн төлөв сайжирч байгаа ч

хэрэглэгчид орон сууц худалдан авах боломжийг сайжруулах шаардлагатай хэвээр байна." гэжээ.

Эх сурвалж: [www.reuters.com](http://www.reuters.com)

### ХЯТАД УЛСЫН ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 2024 ОНД 10.4 ХУВИАР БУУРЛАА.

Хятад Улсын статистикийн үндэсний хорооноос гаргасан мэдээллээр Хятадын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хөрөнгө оруулалт 2024 оны



эхний 10 сарын байдлаар 10.3 хувиар, эхний 11 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 10.4 хувиар буурсан байна.

2024 оны эхний 10 сарын байдлаар үл хөдлөх хөрөнгийн борлуулалт 15.8 хувиар, эхний 11 сарын байдлаар 14.3 хувиар тус тус буурчээ.

Эх сурвалж: [www.reuters.com](http://www.reuters.com)

### КАНАД УЛС 2035 ОНД НҮҮРСТӨРӨГЧИЙН ЯЛГАРЛЫГ 40-50 ХУВЬД ХҮРГЭХ ШИНЭ ЗОРИЛГО ТАВИВ.

Канад Улсын Уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 2035 он гэхэд нүүрстөрөгчийн ялгарлыг 45-50 хувиар бууруулах шинэ зорилго тавилаа.



Энэхүү шинэ зорилго нь Канадын засгийн газраас дэвшүүлсэн зорилтын хүрээнд 2023 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 2005 онтой харьцуулахад 40-45 хувиар бууруулах хуулийг баталсан. Энэхүү шинэ зорилго нь Парисын хэлэлцээрийн хүрээнд олон улс орон дэлхийн дулаарлын томоохон шалтгаан болж буй "Нүүрстөрөгчийн ялгарлыг цэвэр дүнгээр тэг (Net-zero) хүргэх" зорилтын эхлэл болж байна.

Канад Улс нь газрын тосны үйлдвэрлэл, байгалийн хийн үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлдэг бөгөөд хүлэмжийн хийн ялгаруулалтын эсрэг хариу арга хэмжээ авах зорилгоор Засгийн газраас 2030 он хүртэлх уур амьсгалын өөрчлөлт тэмцэх, ногоон эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн шийдвэрүүд гаргаж байгаагаа мэдэгдлээ.

Эх сурвалж: [www.reuters.com](http://www.reuters.com)

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2024 оны 11 дугаар сарын 30-ны өдөр

S&P 500 (^GSPC)

**6,084.19** +49.28 (+0.82%)



Nikkei 225 (^N225)

**39,849.14** +476.91 (+1.21%)



FTSE 100 (^FTSE)

**8,321.34** +19.72 (+0.24%)



NASDAQ Composite (^IXIC)

**20,034.89** +347.65 (+1.77%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia

